



## **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**2022.01.25**

**Баянцогт**

### **Нэг.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол Улсын Үндсэн хуулийн 30 жилийн ойн хүрээнд сумын “Хүүхэд хөгжлийн төв”-тэй хамтран халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ахлах, дунд ангийн сурагчдад хуулийн сургалт хийж “Элсэн цаг” танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулан ажиллалаа. Мөн цахимаар Монгол Улсын Үндсэн хуулийн талаарх сургалт, мэдээ мэдээллийг иргэдэд хүргэн ажиллалаа.

Цэргийн шинэчилсэн бүртгэлийг цахимаар зохион байгуулах сумын Засаг даргын захирамж гарган 2022 оны 01 дүгээр сарын 07-21-ний хооронд зохион байгуулж Аймгийн цэргийн штабт хамрагдалтыг 100% хамруулан мэдээ тайланг хүргүүлэн ажиллалаа.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын тохиолдол эрчимтэй нэмэгдэж эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан санамж зөвлөмжийг иргэдэд тогтмол хүргэн вакцины 4-р тунд идэвхтэй хамрагдуулах ажлыг Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулж байна.

### **Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр:**

ЗГХАА газраас Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох 3 хоногийн сургалтад 8 хүн хамрагдсан байна.

“Хуулийн цаг” арга хэмжээний төлөвлөгөө гарган нийт ЗДТГ-ын албан хаагчид өөрсдийн ажил мэргэжлийн чиглэлийн талаарх сургалтыг 7 хоног бүр сурталчилан ажиллаж байна.

Эрх зүйн хөтөчийн булангаар үйлчлүүлж байгаа иргэдэд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль,гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, зөрчлийн тухай хуулиар мэдээлэл бэлтгэн гарын авлага тараан Орхонтуул ЗДТГ, Рашаант тосгоны захирагчийн албаны фэйсбүүк хуудсанд байршуулсан.

**Улсын бүртгэл:** Улсын бүртгэлийн ажил үйлчилгээний хүрээнд : 01-р сард Шинэ төрсөн-3, Нас барсан -1, Гэрлэлт-1, Шилжиж ирсэн-3, Лавлагаа – 14, Дахин гэрчилгээ-1, Иргэний үнэмлэх: шинэ-4, Сунгалт- 5, Дахин -0, Олголт- 8, Газар-0, Үл хөдлөх –1 нийт 41 бүртгэл хийж үндсэн мэдээллийн санд оруулан баталгаажуулсан байна.

**Нийгмийн даатгал:** 2022 оны 01 дүгээр сард Нийгмийн даатгалын төвлөрсөн санд-17458.1, ЭМД-ын санд-2943.2 мян.төг, Нийгмийн даатгалын Сайн дурын даатгалд- 11 малчин ,1 ажилгүй иргэн, Тэтгэвэр 591 иргэнд 217313.7мян төгрөг, Ажилгүйдлийн тэтгэмжинд-3 хүнд 2637.4 мян тус тус олгон ажиллалаа. Оршуулгын тэтгэмжид-2 иргэнд-2000.0 мян төгрөг, Жирэмсэн амаржсаны тэтгэмж 1 иргэнд-2116.4 мян төгрөг, Харилцагч банкаа солиулж өөрчлүүлэхээр хүсэлт-2 шийдвэрлэсэн. Тэтгэвэр шинээр тогтоолгох хүсэлт гаргасан-9, тэжээгчээ алдсаны тэтгэвэр-1, тахир дутуугийн тэтгэвэрт-2 нийт 12 иргэний хүсэлтийг шийдвэрлэн ажиллалаа.

**Татварын чиглэлээр:** 2022 онд Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор татварын төлөвлөгөөнд мөн өөрчлөлт орсон. Энэ онд 233,112,0 мян/төг-ийг сумын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу сумын санхүү албатай хамтран сумын орлогын төлөвлөгөөний хуваарийг гарган сумын ЗД-ын захирамжаар баталгаажуулан хэлтэст хүргүүлсэн.

Сум болон аймаг улсын сарын төлөвлөгөөний хуваарийн дагуу 1-р сарын төлөвлөгөө 1 сарын 24-ны байдлаар сумын төсөвт 19336,9 мян/төг төвлөрүүлэхээс 11436,5 мян/төг төвлөрүүлэн 59,1% -ийн биелэлттэй байна.

**Газар зохион байгуулалт:** 1 иргэний өргөдөл гомдол хүсэлтийг хүлээн авч гомдол хүсэлтийн дагуу асуудлыг шийдвэрлэн мэдээллийн санд шинэ нэгж талбар оруулж шинэ хаяг өгч ажилласан. Газрын эрх шилжүүлэх 1 иргэний 4 нэгж талбар газрыг шилжүүлж ажиллалаа.

**Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт:** Нийгмийн халамжийн сангийн халамжийн тэтгэвэр-69 иргэнд 13053,8 төгрөг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр-20 иргэнд 3893,4 мянган төгрөг, Асаргааны тэтгэмж-60 иргэнд-5135,89 мянган төгрөг, Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж-5 иргэнд-891,4 мянган төгрөг олгосон байна. Алдар цолтой ахмад настан 2 иргэнд түлшний хөнгөлөлт-280,0 төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 1 иргэнд 1200,0 мянган төгрөг, Алдарт эхийн одонгийн мөнгөн тэтгэмж-370 иргэнд 46400,0 мянган төгрөг, Насны хишгийн тэтгэмж-169 иргэнд-13320,0 мянган төгрөг, Эх олон хүүхэдтэй эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмж-163 иргэнд-8003,8 мянган төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмж-26 иргэнд-990,9 мянган төгрөгийн тус тус олгосон байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 10 өрхийн 56 иргэнд 696,0 мянган төгрөгний хүнсний 10 нэр төрлийн бүтээгдхүүнийг 01-р сард олгосон байна.

#### **Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:**

Хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд шинэ ажлын байранд 3 иргэн, ажилд зуучлагдсан 7 иргэний мэдээллийг шивж, аймгийн Хөдөлмөрийн хэлтэст явуулав. Хөдөлмөрийн зах зээлийн Lmiss программд ажил хайгчаар шинээр 8 иргэнийг бүртгэж, идэвхгүй болсон 4 иргэний мэдээллийг шинэчлэн бүртгэсэн бөгөөд ажил идэвхтэй хайгч 25 иргэн бүртгэлтэй байна.

#### **Хоёр.НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор сумын засаг даргын 2022 оны 01 сарын 13-ны өдрийн А/03 тоот захирамж гарган уяачдын холбоо иргэдэд хүргэсэн. 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөө болон судалгаануудыг шинэчлэн гаргаж мэдээллийн санг шинэчилсэн. Хамтарсан багийн “Орхонтуул сум хамтарсан баг” фэйсбүүк хуудас нээн ажиллуулж байна.

#### **Гурав. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Мал эмнэлгийн чиглэлээр:

Мал эмнэлгийн тасаг, МЭҮН-ийн хамтарсан хурал хийж 2022 онд хийх ажлын төлөвлөгөөгөө хэлэлцсэн.

Мал аж ахуйн чиглэлээр:

Аймгийн аварга малчин өрхийн болзол хангасан 3 малчны холбогдох материалыг бүрдүүлж аймгийн ХХАА-н газарт хүргүүлсэн. Мөн сумын сайн малчин

өрхийн болзол хангасан 9 малчин, 1 фермерч, сумын алдарт уяачийн болзол хангасан 2 уяачийн холбогдох материалыг бүрдүүлж сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Газар тариалангийн салбарт өндөр амжилт гаргасан 3 иргэнийг аймгийн аварга тариаланчаар, 1 аж ахуй нэгжийг Аймгийн аварга тариаланч хамт олноор, Улсын аварга тариаланч хамт олноор 1 аж ахуйн нэгжийн холбогдох материалыг бүрдүүлж дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллалаа..

### **Дөрөв.ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

2022 оны 01 сарын 01-нээс 01 сарын 25 -ныг хүртлэх хугацаанд тус сумын Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжилт авдаг байгууллага болох сумын ЕБСургууль, Рашаант ЕБСургууль, Орхонтуул ЭМТөв, Рашаант ЭМТөв зэрэг төсөвт байгууллагууд, ЗДТГазар Соёлын төв, ИТХурал, Рашаант захирагчийн алба, Рашаант Соёлын төвийн үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас ажил гүйлгээ ЗГУМСистемд шивж баталгаажуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж шуурхай удирдлагаар ханган ажилласанаар төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээлэл цаг хугацаандаа, үнэн зөв, бүрэн мэдээлэгдсэн.

Аймгийн статистикийн хэлтэст графикийн дагуу ХАА-1,2 мэдээ буюу төлийн мэдээ, ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ илгээсэн ба ХАА-н программд болон Medee1212.mn программд шивж , баталгаажуулсан байна.

### **ТАЙЛАН БИЧСЭН:**

**ТӨРИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХ**

**ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН**

**Ж.УНДАРМАА**

### **ТАНИЛЦАЖ, ХЯНАСАН:**

**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН**

**ГАЗРЫН ДАРГА**

**Ш.ӨНӨРБАЯР**